



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2021 оны 02 сарын 04 өдөр

Дугаар 36

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа сунгах,  
үнийг шинэчлэн тогтоох зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 2 дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 7.1, 7.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Хөдөө аж ахуйг дэмжих сангийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 166,500,000.00 /нэг зуун жаран зургаан сая таван зуун мянга/ төгрөгийн балансын үнэ бүхий, элэгдлээрээ анхны өртөгөө нөхсөн, цаашид ашиглаж болох автомашины ашиглах хугацааг сунгаж, үнийг 49,950,000.00 /дөчин есөн сая есөн зуун тавин мянга/ төгрөгөөр шинэчлэн тогтоож, хавсралтад заасны дагуу Ховд аймгийн Мал эмнэлгийн газарт балансаас балансад шилжүүлэхийг зөвшөөрсүгэй.

2. Хөдөө аж ахуйг дэмжих сангийн гүйцэтгэх захирал Э.Батбаяр, Ховд аймгийн Мал эмнэлгийн газрын дарга Д.Батцэнгэл нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хөрөнгийг хүлээлцэх, ашиглалтын хугацаа, үнийг шинэчлэн тогтоох, хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусгах;

2.3. Автомашины улсын бүртгэлийг шилжүүлж, арга хэмжээний биелэлтийг 2021 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА


Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

13201095

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2021 оны 02 дугаар сарын 04-ний өдрийн  
36 дугаар тогтоолын хавсралт



Хөдөө аж ахуйг дэмжих сангийн ажлын албаны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй  
үлдэх өртөггүй, ашиглах хугацааг сунгаж, үнийг шинэчлэн тогтоон Ховд  
аймгийн мал эмнэлгийн газарт балансаас балансад шилжүүлэх автомашин

№	Хөрөнгийн нэр	Үйлдвэрлэсэн, ашиглалтанд орсон он	Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Шинэчлэн тогтоох үнэ (төгрөг)	Цаашид ашиглах жил
1	Ланд крузер-200 улсын дугаар 28-38 УНУ, арлын дугаар JTMHXO5J004040670	2013/2013	166,500,000.00	49,950,000.00	3
	Нийт дүн		/Нэг зуун жаран зургаан сая таван зуун мянга/	/Дөчин есөн сая есөн зуун тавин мянга/	/Гурав/